



**ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН  
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ**

2020 оны 04 сарын 27 өдөр

Дугаар 1/199

Арвайхээр

Газар эзэмших эрх шинээр олгох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, Газрын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.3.2, 33 дугаар зүйлийн 33.1.1 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Арвайхээр сумын 13 дугаар баг Мэргэд 4 дүгээр гудамж 300 тоотын баруун урд 0.0853 га газрыг Арвайхээр сумын 11 дүгээр тусгай цэцэрлэгт боловсролын байгууллагын зориулалтаар, 12 дугаар баг Үйлдвэрлэлийн 1 дүгээр гудамж 111 тоотын урд Өвөрхангай аймаг дахь Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар (9047646)-т 1 га газрыг төрийн байгууллагын зориулалтаар, Үйлдвэрлэлийн 3 дугаар гудамж 305 тоотын хойно Тэргүүн хайрхан ХХК (3566102)-д 0.25 га газрыг үйлдвэрлэлийн, иргэн Э.Мөнх-Очир (ЙЮ90031137)-т 0.25 га газрыг үйлдвэрлэлийн зориулалтаар тус тус 30 жилийн хугацаатайгаар эзэмшүүлсүгэй.

2. Дээрх газар эзэмших эрх авсан хуулийн этгээдтэй газар эзэмших гэрээг байгуулж, эрхийн гэрчилгээ олгон, газрын улсын бүртгэлд бүртгэхийг аймгийн Засаг даргын дэргэдэх Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар (Ч.Гүнсэнхорол)-т үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Г.ГАНБОЛД

011100383